



**ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 5/18

Өмнөдэлгэр сум

**Нэмэгдэл хөлс олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4.3, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Хагас жилийн мал тооллого, гамгаас хамгаалах иж бүрэн сургуультай холбогдуулан сумын Шуурхай штабын жижүүрээр дайчлагдан ажилласан албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосугай.

2.Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.


3.Нэмэгдэл хөлсийг Засаг даргын Тамгын газрын цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.БАЯРМАА



Засаг даргын Тамгын газрын даргын  
2025 оны .... дугаар сарын ....-ний өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт



Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох албан хаагчид

| №  | Овог нэр     | Албан тушаал                             | Илүү цаг |
|----|--------------|------------------------------------------|----------|
| 1  | Т.Эрдэнэтуяа | Нийгмийн бодлогын<br>мэргэжилтэн         | 16       |
| 2  | Х.Саруултуяа | Хөдөө аж ахуйн тасгийн дарга             | 16       |
| 3  | Т.Одончимэг  | Хөдөө аж ахуйн тасгийн<br>мэргэжилтэн    | 16       |
| 4  | Т.Чинхуяг    | Байгаль орчны хяналтын улсын<br>байцаагч | 16       |
| 5  | С.Батсуурь   | Төсөв, төрийн сангийн<br>мэргэжилтэн     | 16       |
| 6  | Э.Ууганцэцэг | Санхүү албаны дарга                      | 16       |
| 7  | Б.Гантулга   | Нягтлан бодогч                           | 16       |
| 8  | Ц.Бямбасүрэн | Сангууд хариуцсан нягтлан<br>бодогч      | 16       |
| 9  | М.Уянга      | Архив, бичиг хэргийн ажилтан             | 16       |
| 10 | Э.Цэвэг      | Нярав                                    | 16       |
| 11 | Г.Сэргэлэн   | Үйлчлэгч                                 | 8        |
| 12 | Э.Батбаяр    | Жижүүр                                   | 16       |
| 13 | Ш.Ганбаяр    | Жижүүр                                   | 16       |
| 14 | Д.Цогтоо     | Жижүүр                                   | 16       |
| 15 | Т.Амарсанаа  | Жолооч                                   | 8        |